



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 2/414

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.2.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 3.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Политехник коллежийн оюутан суралцагчидтай зохион байгуулах “Оюутан цэрэг” сургалтын онолын хичээлүүдийг явуулах, тэдэнд цэрэг-эх оронч үзэл хүмүүжил олгох “Цэрэгжилтийн танхим”-ыг тохижуулж, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд зориулж 2,474,750 (хоёр сая дөрвөн зуун далан дөрвөн мянга долоон зуун тавь) төгрөгийн дэмжлэг үзүүлж, хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

6223 11 0800

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны... дугаар
сарын...-ны өдрийн... дугаар
захирамжийн хавсралт
хавсралт



ЦЭРЭГЖИЛТИЙН ТАНХИМ БАЙГУУЛАХ
ТӨСВИЙН ТООЦОО

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Материалын үнэ (төгрөг)
1	Төрийн сүлд (хөөсөн хавтан)	50x50см 1 ширхэг	1x0,25м ² =18750
2	Төрийн далбаа	1x2 метр 1 ширхэг	40.000
3	Монгол Улсын Төрийн дуулал, цэргийн тангараг (хөөсөн хавтан самбар)	50x80см 2 ширхэг	2x0,40м ² = 60000
4	Цэргийн албаны тухай, Цэргийн дотоод албаны дүрмийн үзүүлэн самбар (хөөсөн хавтан самбар)	1.2м x 80см 2 ширхэг	2x1м ² = 150 000
7	Жагсаалын бэлтгэлийн үзүүлэн самбар (хөөсөн хавтан самбар)	1.2м x 80см 2 ширхэг	2x2м ² = 150 000
8	Галын бэлтгэл (7.62 мм АКМ, ПМ гар буу)-ийн үзүүлэн самбар (хөөсөн хавтан самбар)	1.2м x 80см 1 ширхэг	1x1м ² = 75000
9	Өвөрхангай аймгаас төрсөн генералуудын хөрөг зураг (хуулбар)	20x30см 11 ширхэг	11x6000= 66 000
10	“Монгол цэрэг 1939 оны Халхын гол, 1945 оны Чөлөөлөх дайнд” фото самбар (хөөсөн хавтан самбар)	1.2м x 80см 1 ширхэг	1x1м ² = 75 000
11	“Монгол цэрэг дэлхийн цэрэг”, Монгол цэргийн түүхэн хөгжил фото самбар (хөөсөн хавтан самбар)	1.2м x 80см 2 ширхэг	2x2м ² = 150 000
13	LED телевизор	1 ширхэг	1 000 000
14	Ханын цаг	1 ширхэг	40 000
15	Тугны суурь	1 ширхэг	40 000
16	Зургийн жааз	21x30см 11 ширхэг	11x10 000= 110 000
17	Танхимын дотоод засварт	-	500 000
Дүн			2 474 750